

Манмин Мэдээ

№ 66 2018 оны 11 сарын 25



Сүм байгуулагдсаны 36н жилийн ойн баярын үйл ажиллагаанд гадаадын 22 улсын зочид оролцож, GCN (Жи Си Эн) телевизээр дэлхий даяар шууд дамжууллаа

2018 оны 10-р сарын 7 ны (Эзэний өдөр) үдээс хойш 15 цаг, Сүм байгуулагдсаны 36 ойн баярын цуглаан болон тоглолтоор Бурхандаа талархал алдрыг өргөсөн юм. Энэ өдрийн үйл ажиллагаанд АНУ, Колумба зэрэг гадаадын 22 орны зочид оролцож, 31 орноос Манмин төв сүм байгуулагдсаны 36 жилийн ойн баярын видео мэндчилгээ, болон захидлаар баярын мэндчилгээ илгээсэн байлаа.

Дэлхий даяар 170 гаруй оронд нэвтрүүлгээ цацдаг GCN (Жи Си Эн) телевиз болон интернэтээр шууд дамжуулагдсан баярын үйл ажиллагааг англи, хятад, япон, орос, франц, испани, монгол, вьетнам гэх мэт 8 орны хэлээр шууд орчуулагдан цацагдсан юм.

Баярын үйл ажиллагаа 1-р хэсгээр ерөнхий удирдагч И Сү жин пастор 'Алдар' (Исаиа 60:1-3) гэсэн сэдвээр гэмт явдал хорон муугаар харанхуйлагдаж байгаа эцсийн энэ үед үнэт эрдэнэ мэт итгэлээр Бурханыг баярлуулан үйлдсэнээр бүтээгч Эзэн Бурханы алдрыг бүх дэлхий даяар илэрхийлэхэд гол үүрэг гүйцэтгэх хэрэгтэй чухалчилж байлаа.

Түүний дараа сүмийн урлагын хорооноос бэлтгэсэн баярын тоглолт нь 'Цэцэгт замаар найрын өргөөнд' гэсэн сэдвээр тусгайлан бэлтгэсэн тайзанд 40 минут үргэлжилсэн гайхалтай тоглолт болж өнгөрсөн юм. Өнгө алагдсан цэцэгсээр дүүрэн маш үзэсгэлэнтэй тэнгэрийн орны баяр найрын өргөө, анхилуун цэцэгт замаар явах тусам тэр баяр хөөр дүүрэн уур амьсгал, магтаал дуу болон бүжгээр илэрхийлэгдсэн энэ тоглолтонд Хан Жү геон магтаалын номлогч, сүмийн урлагын хорооны

магтаалын баг, бүжгийн баг, хөгжимчид, Нисси оркестр, Иммануел ариун хоор дууны баг, мөн тайз гэрлийн техникчид зэрэг 290-д хүний бүрэлдэхүүн бие сэтгэлээр бүтсэн баярын тоглолт болж өнгөрлөө.

Мөн энэ өдөр сүмийн гадаа урд хэсэгт 'Цэцэгт замаар найрын өргөөнд' гэсэн сэдвээр хийсэн дурсгалын зураг авхуулах талбайг бэлтгэж, мөн бүчимгэ хайрмал, хөөсөн чихэр, хулууны чихэр зэрэг эрэгтэй эмэгтэйчүүдийн баг, Канаан, залуучуудын багаас сэтгэлээсээ зориулсан арвин их амтат хоол, хачир амттанаар дүүрэн талбайг засаж, оролцсон итгэгчид төдийгүй уригдан ирсэн зочдод гайхалтай дурсамж үлдээсэн өдөр болж өнгөрсөн юм.

Цаг агаарын урьдчилсан мэдээгээр Конрей гэх

далай хар шуурганы улмаас 10-р сарын 6ны (Бямба гариг) т их хэмжээний бороотой, хүчтэй салхитай гэж байсан ч ойн баярын үйл ажиллагааны сүмийн гаднах бэлтгэл ажил тус өдрийн 13 цагт товлогдсон байсан ба тухайн цаг болох үед цаг агаарын байдал сайжирч, бүх бэлтгэл ажил төлөвлөсөний дагуу хийгдэж, маргааш Эзэний өдрийн гадаах үйл ажиллагаа ч маш таатай дулаахан нөхцөлд болсноороо итгэгч нарт илүү их ивээл өгч байлаа.

Мөн уг баярын өмнө үйл ажиллагаа буюу 10-р сарын 5 ны Баасан гаригийн оройн цуглааны 2-р хэсэгт "Шинэ Иерусалим руу чиглэн" гэсэн магтаалын цуглаан болж итгэгч нарын чин сэтгэлийн талархал ба тэмүүлэл шингэсэн магтаалын цаг, бүжиг хөдөлгөөнөөр Бурхандаа алдрыг өргөсөн цаг болж өнгөрсөн юм.

“Тун удалгүй агуу ихээр илчлэгдэх Манмины үйлчлэлд найдаж байна”

Сергей Бочарников пастор Израйль улс Назарет мөнх амь чуулган



Ойн баярын тоглолтоор тэнгэрийн орон Шинэ Иерусалим ариун хотын нэг хэсэг энэ газарт буугаад ирсэн мэт маш их сэтгэл хөдлөж, ивээл их авлаа. Тэр газар руу явъя гэсэн хүсэл тэмүүлэлээр дүүрсэн ерөөлийн цаг байлаа.

Ялангуяа манай Израйлийг хайрлаж, үргэлж хамт байдаг И Жей руг доктордоо талархалын сэтгэлээ дамжуулж байна. И Жей руг докторын залбирч

өгсөн, мөн сэтгэл санаа эд материал гэх мэт бүх талаар дэмжиж байгаад чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Манминий үйлчлэлээр дамжуулан бүх дэлхий даяар Эзэн Есүс Христийн сайн мэдээ хүчтэйгээр тархаж, доктороор дамжуулагдах Бурханы сайхан хүсэл агуу ихээр илчлэгдэн гарахыг найдаж хүлээж залбирч байна.

Эелдэг байдлын мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кёонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Шатар тоглож байхад хөндлөнгөөс харж байгаа хүн гурван нүүдлийг хардаг гэсэн үг байдаг. Хоорондоо тоглож буй хоёр хүн хэдий туршлагатай сайн тоглодог ч их бага хэмжээний сэтгэл зүйн ачаалал дарамт авдаг тул амархан нүүдлийг ч сайн харж чадахгүй тохиолдол их бий. Гэвч хажуу талаас нь ажиглаж буй хүн тус тоглолтын ялалт ялагдлын дарамт байхгүй тул тэр хэмжээгээр чөлөөтэй харж, харах хүрээ өргөн болдог. Итгэлийн амьдрал ч мөн үүнтэй адил байдаг.

Өөрийн эрх ашгийг хайх үед үнэн зөвийг ялгаж чадахгүй тохиолдол их байдаг. Хэдийгээр юу нь үнэн, зөв болохыг мэддэг байлаа ч нүднийх нь өмнө өөрийн эрх ашигтаа автаж үнэний дагуу үйлдэж чаддаггүй. Тиймд аар саар шуналыг хаяад сэтгэлээ Бурханы үгээр дүүргэвэл үнэн зөв зүйлийг амархан ялгаж чадах ба, үнэний дагуу үйлдэх тийм ч хэцүү биш юм. Бусад хүмүүсийн асуудалд ч мөн маш тодорхой хариулт өгч чадах юм. Үүнийг л эелдэг байдлын мэргэн ухаан гэж байгаа юм.

1. ‘Эелдэг байдал’-н сүнс талын утга

Хэлний тайлбар толь ‘Эелдэг байдал’-н талаар үзвэл ‘Өршөөн уучлах, хүлээж авах’ гэж тодорхойлсон байна. Тэгвэл Бурханы айлдаж буй эелдэг байдал ‘Үнэний сэтгэл дүүрэн байх ба үүний хамт үнэний эрх чөлөө байдаг тул өөрт байгаагаа бүгдийг зориулж чадах сэтгэл’ гэсэн байдаг. Ингэж өөрийгөө бүрэн зориулахын тулд өөрийнхнөө эрэх, амин хувиа бодох сэтгэлгүй, үнэнээр дүүрсэн байх ёстой юм.

Үнэнээр дүүрсэн сэтгэлээр бүх зүйлээ зориулж өгсөн хамгийн сайн жишээ бол Есүс юм. Бурханы Хүү болох Есүс ямарч гэм буруу, алдаа буруутгал байхгүй бөгөөд Түүний сэтгэл төгс үнэний эх ундарга байсан юм. Энэ газар дээр байх хугацаандаа ч зөвхөн Бурханы хүслийн дагуу амьдарч, Өөрийн бүх зүйлээ бүрэн зориулсан юм. Сайн идэж, ууж ч чадалгүй, тухтай ч амрах завдалгүй тэнгэрийн сайн мэдээг тарааж, өвчтэйг эдгээж, хүмүүсийн төлөө маш их хичээл зүтгэл нулимс урсгаж, эцэст нь мөнх амийг хүртэл өгч, үй олон хүмүүсийг аварч тэнгэрийн орон руу хөтлөх боломжтой болсон юм.

Эхлэл 13-р бүлэгт гардаг Абрам (Абрахам)-н үйлсээр дамжуулан мэдэх боломжтой. Бурханы ерөөлийг авч мал сүрэг нь олширсон Абрахам ба Лотын малчдын хооронд худаг бэлчээрээ булаалдан маргалдан болж байв. Энэ үед Абрам нь дүү Лотоос тусдаа амьдрахаар шийдэж, “Чи зүүн тийш явбал би баруун тийш явж, харин чи баруун зүг явбал, би зүүн зүг рүү явна” гэжээ. Тэгтэл Лот нь Абрамын хувьд насаар бага, доод хүн бөгөөд мөн түүний авсан ерөөл ивээл нь ч Бурханы хайрыг хүртсэн Абрамтай хамт байснаар ингэж ерөөгдсөн ч дуртайяа Абрамын үгийг хүлээн авч, үржил шимтэй ус ундтай өргөн уудам бэлчээрийг түрүүлж сонгодог. Гэсэн ч Абрам үүнд огтхон ч гомдсонгүй. Хичнээн л бол зориулж өгөх дутуу байна гэж дахин шаардсан ч бүхнээ зориулж чадах уудам сэтгэлтэй учраас юм. Тийм ч учраас Бурхан Абрамд дөрвөг зүг найман зовхист харагдаж буй бүх газрыг түүнд өгөхөө амлаж, мөн түүний удам далайн эргийн элс мэт үй олон болгож өгөхийг

амласан юм.

Энэ мэт Абрам нь бүр бялхам дүүрэн эелдэг зан ба ууч сэтгэл гарсандаа биш өөрийн хийх ёстойгоосоо илүү давсан сайныг үйлдсэн учраас Бурханы өмнө агуу ерөөлийг хүртсэн юм. Ертөнцөд өөрийн юмыг зориулахаас илүү харин өөрийн юмыг сахин хамгаалдаг хүнийг ухаалаг хүн гэдэг. Нэг алгадуулбал, нэг алгадах ёстой, нэгийг өгвөл түүнээсээ илүүг авах нь мэргэн ухаан гэгддэг. Гэтэл “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” (Үйлс 20:35) гэсний дагуу Эзэний нэрээр ивээнэ, хуваана гэдэг нь Бурханаас ерөөл авах арга бөгөөд жинхэнэ мэргэн ухаан юм.

Өөрийн эрх ашгийг хайх сэтгэл, уур хилэн, шунал зэрэг байх тусам эелдэг ууч сэтгэл гарах боломжгүй юм. Тийм ч учраас эелдэг ууч сэтгэлийн сүнс талын утга нь ‘Үнэний сэтгэл дүүрэн байдаг тул өөрт байгаагаа бүгдийг зориулж чадах сэтгэл’ гэж тодорхойлсон байдаг.

2. ‘Эелдэг ууч сэтгэл’-н мэргэн ухаанаар авдаг ерөөл

Үнэнээр зүрх сэтгэлээ дүүргэж, өөрийгөө зориулж, үйлчилнэ гэдэг нь хүний итгэл сэтгэлийг олох ухаан юм. Зүрх сэтгэлээ үнэнээр дүүргэж ууч сэтгэлээр хандахад өөрийн зүйлийг хувааж өгсөн ч хайран биш бөгөөд бусад хүн өөрөөс нь илүү гарсан ч сэтгэл тавгүйтдэггүй. Бусад хүн илүү амжилтанд хүрэхэд нь тусалж өгөн, нүдэнд харагдах жижиг ашиг сонирхолтой зууралддаггүй. Ийм хүн Бурханы өгдөг ерөөл авбал ‘Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй. Үйлчилдэг нь агуу нэгэн болно’ гэдэг сүнс талын мэргэн ухааныг ойлгодог.

Би үүнийг сайн мэддэг тул сүм байгуулаад тийм ч хангалуун бус байхдаа ч бусад сүм байгуулагдаж байхад дэмжлэг үзүүлж байлаа. Хэрэглэх зүйлээ ариглан хэмнэн хэмнэсээр дэлхий даяар сайн мэдээ тараах, хүмүүсийн авралын ажилд зориулсаар ирсэн. Дотуур хувцсаа өгөөч гэсэн хүн байсан ч тэр аварч л байвал гадуур хувцсаа хүртэл өгч, хилсээр баруун хацраа алгадуулаад эвтэй байх бол зүүн хацраа ч мөн тавьж өгсөн юм.

Заримдаа хуурч байгааг нь мэдсэн ч хуурагдаж өгч, эсэргүүцэх тэмцэх хүчгүйдээ хохирч өгөн, ертөнцийн амьдрал мэдэхгүйдээ зориулж өгч байгаа хэрэг огт биш юм. Хүмүүсийн авралын төлөө чин сэтгэлээр хандаж, бүхнийг чадагч Бурханы хүч нөлөөнд итгэдэг болохоор юм. Тийм учраас л Бурхан богино хугацаанд агуу том цуглаан болгон өсгөж, сүм чуулган цаг хугацаа өнгөрөх тусам улам арвин ихээр өсч байлаа.

Бурханы хаанчлал ба итгэгч нартай харьцахдаа ч мөн адил юм. Элч Паул “Би ихэд баяртайгаар зарж үрэх бөгөөд та нарын сүнснүүдийн төлөө өөрийгөө ч гэсэн үрэх болно. Хэрэв би та нарыг илүүгээр хайрлавал өөрөө багаар хайрлагдах уу” (2 Коринт 12:15) гэсэн байдаг. Бид Бурханы хайрлаж, хүмүүсийг хайрлан бүх зүйлээ зориулж өгөх үед үнэнийг мэдэхгүй хүмүүсийн нүдэнд энэ нь огт ашиггүй хоосон үйлдэл мэт харагдаж болох юм.

Гэсэн ч тэгэх тусам Бурхан ба хүмүүсийн өмнө


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

илүү ихээр хүндлэгдэн хайрлагдах болдог. Элч Паул бүх зүйлээ зориулах үед Тимот шиг түүнийг аав гэж дуудахуйц хайрладаг ажилтнууд гарч ирэн, боломжтой бол нүдээ ч ухаад өгөх хэмжээгээр түүний хайрладаг чуулган ба итгэгч нар гарч ирсэн юм (Галат 4:15). Түүнчлэн үнэн зөвийг ялгаж чадах мэргэн ухаантай болж, мөн хүмүүсийг дахин амьдруулах өчүүхэн нэгнийг ч босгож чадах хүчтэй болдог.

3. Эелдэг ууч сэтгэлээс гарах үнэний эрх чөлөө

Үнэнийг сэтгэлдээ дүүргэхийн хамтаар мөн үнэн доторх эрх чөлөөг эдэлдэг тул өөрийн бүх зүйлээ бүрэн зориулах чадах сэтгэлийг “Эелдэг байдал” гэдэг. Тэгвэл ‘Үнэний эрх чөлөө’ гэж юу вэ? Иохан номын 8:32д үзвэл “Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө” гэсэн байдаг. Үнэн болох Бурханы үгээр амьдарч чаддаггүй хүнд үнэний үг дөнгө мэт санагддаг. Гэтэл үнэнийг үг сургаалийг хайрлаж, үйлддэг хүн түүний дотор эрх чөлөөг эдэлдэг. Бурханы хууль бол хайр бөгөөд ерөөлийн суваг гэдгийг мэддэг тул айх явдал байдаггүй.

Жишээ нь Амралтын өдрийг төгс сахих итгэлгүй хүнд ‘Амралтын өдрийг ариунаар сахь’ гэсэн тушаал дарамттай санагддаг. Амралтын өдөр ажил хийхгүй, ертөнцийн зугаа цэнгэлд бүү авт гэсэн үг нь яг л гав гинж зүүлгэсэн мэт санагддаг. Гэтэл зүрх сэтгэлээсээ баяр хөөртэйгөөр Амралтын өдрийг сахидаг хүн ийм сургаалиас дарамт мэдэрдэггүй. Эзний өдрийг сахина гэдэг нь Бурханы сүнс талын агуу эрх мэдлийг хүлээн зөвшөөрч буй хэлбэр бөгөөд ингэснээр өөрөө амар тайван болоод ерөөгдөнө гэдгээ мэддэг учраас юм.

Бид Амралтын өдрийг төгс сахивал нэг долоо хоногийн турш бүх төрлийн осол, гай зовлонгоос хамгаалагдаад зогсохгүй ерөөгдөх боломжтой. Бурхан 6 өдрийн дотор 7 хоногийн турш олох орлого ба түүнээс ч ихийг олохоор ерөөж, аар саар элдэв төлөвлөөгүй зардалуудыг ч хааж өгдөг. Өвчин зовиур, осол бэртлээс ч хамгаалж өгсөнөөрөө эмнэлэгийн төлбөр, эмийн мөнгө зэрэг зарлагуудыг хааж өгдөгөөрөө онцлоготой. Энэ мэт Амралтын өдрийг сахь гэдэг үнэний үгийг мэдэж, үйлдвэл, сүнс сэтгэл сайжрах ерөөл авч, үргэлж Эзэн дотор хамгаалагдах учир амьдралын эрх чөлөөг мэдэрдэг.

Өөр нэгэн жишээ дурьдвал бид үзэн ядалтыг хаявал сэтгэл хөнгөрч аз жаргалаар дүүрдэг. Өмнө нь хэн нэгнийг үзэн яддаг учраас Бурханы эвгүй байдалд байж, сэтгэл санаа ч хүнд байсан бол энэ зүйлээ хаячихвал үнэн тэр гэмийн буулгаас чөлөөлж эрх чөлөөг өгдөг учраас юм. Үнэнээр сэтгэлээ дүүргэвэл өөрөө төдийгүй бусдад ч эрх чөлөөг өгөх боломжтой. Бусад хүн үнэн дотор амьдардаггүй гээд өөрийн санаанд нийцүүлэх гэж шүүн дүгнэж, нүүр буруулах бус харин ч түүнд үнэний дагуу амьдарч чадах хүчийг өгдөг байх хэрэгтэй.

‘Зүрх сэтгэл үнэнээр дүүрэн’ гэдэг нь үнэнийг

толгойгоор мэднэ гэсэн үг биш юм. Үнэнийг зөвхөн толгойгоороо мэддэг хүн бол өчүүхэн зүйлийг мэдээд яг л бүхнийг мэддэг мэт бардамнадаг (1 Коринт 8:1). Ийм хүн бусад хүмүүс үйлчлүүлэхийг хүсэж байгааг хараад шууд л дүгнэж эхэлдэг. Гэвч эцэс нь өөрөө “Ах дүүгээ бүү шүү” гэсэн тушаалыг зөрчиж байгаагаа ухаарч чаддаггүй.

Эсрэгээрээ зүрх сэтгэлдээ үнэнээр дүүрэн хүн бусдыг итгэлийн хэмжээнд тохируулан харж ханддаг. Бурханы үгээр зөв бурууг ялгаж чадах ч, бусдын алдаа дутагдал, худал хуурмагыг хайраар хучиж далдалж өгдөг. Өмнө нь өөрөө ч үй олон алдаа дутагдалтай байсан ч Эзний хайраар энэрэл өршөөлийг авсан шиг бусадтай ч мөн тэгж харьцах ёстой.

4. Эелдэг ууч сэтгэлтэй болоход ирэх цэцэн ухаан

Үнэнээр сэтгэлээ дүүргэн, үнэн дотор эрх чөлөөг эдэлдэг, уужим сэтгэлтэй болвол бүх тал дээр тод замыг харах ‘цэцэн ухаан’ ирдэг. Есүс үнэний эрх чөлөөн дотор хүмүүст Бурханы үгийг дамжуулсан юм.

Иохан номын 8-р бүлэгт үзвэл Иудейчүүд завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйд Есүсийн өмнө чирч ирээд яах ёстойг нь асуудаг. Хуучин гэрээний хуулийн дагуу бол чулуугаар шидэж алах ёстой бөгөөд Есүс тэдэнд хуулийн дагуу “Чулуугаар шид” гэвэл гэвэл ердийн үед хайр ба уучлалыг үргэлж заадаг Есүс Өөрөө зааснаа зөрчлөө гэж ярих байлаа. Эсрэгээр нь “Уучилж явуул” гэвэл “Хуучин гэрээний хуулийг зөрчдөг хүн” гэж дүгнэн ярих болно. Энэ үед Есүс юу ч хариулалгүй доош суун ямар нэгэн зүйл газарт бичиж байлаа.

Хүмүүс хариултаа шавдуулахад “Та нарын дундаас нүгэлгүй хүн нь эхлээд эн эмэгтэй уруу чулуу шид” гэж айлдаад дахин газар бичиж эхлэв. Цугласан олон түмэн Есүсийн бичиж байгаа байдлыг харангаа яагаад ч чулуугаар шидэж чадахгүй байсан юм. Учир нь газар бичсэн зүйл нь цугласан олон түмний гэм нүглийн жагсаалт байсан учраас юм. Мөс чанарын хатгалгад орсон хүмүүс нэг нэгээрээ тэр газраас явсаар эцэстээ тэр эмэгтэй Есүстэй 2 лханаа үлдсэн байлаа. Есүс “Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд” гэж айлдсан юм. Энэ үг айдас ичгүүрт чичирж байгаад амиа аврагдсан тэр эмэгтэйн сэтгэлд гүн суугдсан юм.

Есүс үнэний уг ундарга бөгөөд Бурханы зүрх сэтгэл, Түүний хүслийг маш тод мэддэг тул үнэн доторх эрх чөлөөг бүрэн эдлэж байсан юм. Гэмтнүүдийн сэтгэлийг ойлгож, өршөөнгүй сэтгэлээр хандах эелдэг ууч сэтгэл байсан тул “Гэм нүгэлгүй хүмүүс эхлээд чулуу шид” гэж Бурханы хүслийг ухааруулж чадах мэргэн ухаан гарсан юм.

Хэрэв Есүс жоохон ч гэсэн дүгнэх сэтгэл байсан бол ингэж хариулахгүй байх байлаа. Эмэгтэйг

өрөвдөж шууд л “зүгээр явуул” гэсэн бол “Тэр хуулийг зөрчихийг зааж байна” гэж шүүгдэн маш ярвигтай асуудалд орох байлаа. Мөн бүх хуульд Бурханы хайр агуулагдсан ч гэмтнийг өрөвдөлтэй гээд шууд уучлаад л явуулж болохгүй юм.

Гэм нүгэл нь хөрөнгө мэт исэн томорсоор илүү олон хүнийг мөхлийн зам руу явах болдог учраас юм. Тиймд Бурхан гэм үйлдсэнийх нь төлөө шийтгэлийг товлон тавтсан байдаг. Есүс хуулийг төгс сахин биелүүлж, түүнд агуулагдсан Бурханы сэтгэлийг мэддэг тул бүх хүмүүсийг аврах мэргэн ухаанаар энэ асуудлыг шийдсэн юм (1 Тимот 2:4).

Мөн үүнээс ухаарах ёстой нэг ухаан нь Есүс цугласан олон түмний алдаа дутагдлыг нэгд нэггүй үгээр илэрхийлэлгүй доош суун газарт бичсэнд байгаа юм. Бүх хүмүүсийг ийм тийм гэж айлдвал тэдний сэтгэл тавгүйтэн эвгүйцэх байсан учраас юм. Агтаг хүмүүсийг шүүмжлэхэд ухаарч гэмшихийн оронд улам тавгүйтэж үймээн үүсэхийг мэдэж байсан тул зөвхөн газарт тэдний гэмт үйлдлийг бичиж харуулснаар тэд ухаарч, өөрсдөө орхиж явахаар хийсэн байдаг.

Хэн нэгэн нь бусдын буруутай байдлыг дамжуулбал үүнийг сонсож байгаа хүн шууд хариуг нь хариуг нь өгдөг тохиолдол байдаг. “Чамд ч гэсэн ийм тийм асуудал байгаа биздээ?” гэж амыг тагладаг. Өөрөөр хэлбэл чи өөрийгөө л хичээ гэсэн үг юм. Мэдээж бусдын алдаа дутагдлыг ярьдаг хүн юм. Тэглээ гээд шууд тэр үед ингэж хэлнэ гэдэг нь зөв зүйл биш юм. Хорон мууд хорон муугаар хариулж байгаа хэрэг бөгөөд өөрөө ч дүгнэж шүүж байгаа хэрэг юм. Хэдийгээр тэр яриаг сонсоод өөрийн буруугаа мэдсэн ч сэтгэлдээ тэр хүний талаарх тавгүй ойлголт гомдол тээдэг.

Энэ мэт үнэнийг сэтгэлдээ бий болгоогүй, толгойгоороо мэдлэг хураавал тэр мэдлэгээрээ бусдыг шархлуулахад амархан байдаг. Түүнчлэн Бурхан үгийг сэтгэлдээ биелүүлэх хэрэгтэй бөгөөд тэр үед л бусдыг сэтгэлдээ агуулж чаддаг.

Ийм эелдэг хүн бусад хүмүүсийг сэтгэлийг өвтгөдөггүй. Хэдийгээр эсрэг талын хүн атгаг байдлаар хандлаа ч дүгнэж шүүхгүй ба түүнийг харин ч аврахын тулд үнэн рүү хөтөлж өгдөг. Ийм сэтгэлтэй болсон үед л бусдыг мөнх амь руу удирдах мэргэн ухаантай болдог. Энэ бол эелдэг ууч сэтгэлээс гарах мэргэн ухаан юм.

Хайрт итгэгч та бүхэн, Ром 15-р бүлэг 1-2 ишлэлд үзвэл “Хүчтэй бид өөрсдийнхөө сэтгэлд нийцүүлэлгүй, хүчгүйнхээ сул дорой байдлыг үүрэх ёстой. Бидний хүн бүр хөршийнхөө сайн сайхны төлөө түүнийг босгон байгуулахын тулд сэтгэлд нь нийцүүлэ” гэсэн байдаг.

Бурханы хүүхэд бол сул дорой нэгнийг асран халамжилж, хөршөө баярлуулан сайны үйлсийг хийх хэрэгтэй юм. Уужим эелдэг сэтгэлээр хаана ч, хэзээд сайны анхилуун үнэрээр Бурханы бахархал болсон үр хүүхдүүд болохыг Эзний нэрээр хүсэн ерөөе.

‘2018 Манмин зуны цуглаан’ д оролцсон Оросын номлогчид



Андрей Белейф пастор,
Санкт-Петербург Манмин
чуулган

“Солонгост өнгөрүүлсэн цаг яг л зүүд мэт сайхан цаг байлаа. Зуны цуглааны сургаалийн цагаар сүнсний ертөнцийг нээж чадах ерөөлийн нууцуудыг нэг болох сайны сэтгэл хичнээн дутагдалтай болохоо ухаарсан юм. Маш олон хүмүүс эдгэрч Бурхан болон Эзэндээ алдрыг өргөж байгаад хараад маш их ивээл авсан юм.”



Леонид Артух пастор,
Калининград Шинэ од чуулган

“Зуны цуглааны хаана ч Ариун Сүнсний хүч нөлөө ба ивээлийг авч болохоор байсан ба Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг үйлчилдэг итгэгч нарыг хараад маш аз жаргалтай ивээлтэй байлаа. Маш олон тэмдэг гайхамшиг, хүч нөлөөг харж, эдгэрэл авсан итгэгч нарын гэрчлэлийн талбарт би хамт байгаа нь гайхамшиг байлаа.”



Мэргэн ухааны үүдийг нээх түлхүүр бол Ариун байдал
Жинхэнэ мэргэн ухаан бол толгойноос
бус зүрх сэтгэлээс гардаг.



Ойн баярын өмнөх тоглолт
“Шинэ Иерусалим руу”

Ойн баярын тоглолт
“Цэцэгт замаар найр наадмын өргөөнд”



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин МЭДЭЭ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин